



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/221

Булган

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд  
байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны ээлжит VI хуралдааны 06/06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын 320 хүүхдийн суудалтай сургуулийн хичээлийн байр, урлагийн танхим, цайны газар, номын сангийн өргөтгөлийн зураг төслийн холболтыг “Өрх” ХХК-тай 20000000 /хорин сая/ төгрөгөөр гэрээ шууд байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг холбогдох норм, дүрмийн шаардлагын түвшинд гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Өрх” ХХК /А.Бат-Од/-д даалгасугай.

3. Дээрх зураг төслийн гэрээнд заагдсан санхүүжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны ээлжит VI хуралдааны 06/06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгагдсан төсөл, арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ